

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ БҮХ ХЭЛБЭРИЙГ
УСТГАХ ТУХАЙ НҮБ-Н КОНВЕНЦИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
АСУУДЛААР МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС БЭЛТГЭСЭН
8 БА 9 ДҮГЭЭР ЭЭЛЖИТ ИЛТГЭЛИЙН

СҮҮДЭР ИЛТГЭЛ



МОНФЕМНЕТ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ
2015 ОН

СҮҮДЭР ИЛТГЭЛ

Хэвлэсэн:

МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээ

Хаяг: Улаанбаатар-14201, Ш/х-418, Монгол Улс

Утас: (976) 70110355

И-мэйл: monfemnetzz@gmail.com

Вэбсайт: www.monfemnet.org

Фэйсбүүк: MONFEMNET National Network

Твиттер: @Monfemnet

Юутүб: [youtube.com/user/MONFEMNET National Network](https://youtube.com/user/MONFEMNET%20National%20Network)



Энэхүү тайланг аливаа хэлбэрээр ашиглах тохиолдолд эх сурвалж буюу МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээний нэрийг заавал дурдана.

Товч агуулга

Монголын нийгэмд олон зуун жилээр хэрэглэгдсээр ирсэн эцгийн эрхэт ёсны зан заншил, ёс жаяг нь өнөөгийн улс төр, нийгэм, эдийн засаг, соёлын амьдралд уламжлалт хэлбэр, хандлагаа бага зэрэг өөрчилсөн байдлаар амь бөхтэй оршиж, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах шалтаг, шалтгааныг нөхцөлдүүлсээр байна.

Тийм ч учраас МОНФЕМНЕТ Үндэсний Сүлжээний ТББ-н гишүүн байгууллагууд Конвенцийн хэрэгжилтийн асуудлаар Сүүдэр илтгэл бичих сэдвээ эмэгтэйчүүдийг төр, зах зээл, олон нийт, гэр бүлийн хүрээнд ялгаварлан гадуурхагдах гол шалтгааныг бий болгож байгаа уламжлалт ёс заншил, олон нийтийн хандлагыг өөрчлөх төрийн хариуцлага дээр тулгуурлан бичих нь зүйтэй гэж шийдлээ.

Монгол улс 1981 онд тус Конвенцид нэгдээд 34 жил, хүний эрх, тэгш эрх, ялгаварлан гадуурхалтыг хориглосон, төр засгийн үүрэг хариуцлагыг тодорхойлж тунхагласан Үндсэн хуулиа батлаад 25 жил болж байна. “Монгол Улсын иргэн хүний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”, “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан Үндсэн хуулиндаа заасан ч эмэгтэйчүүдийн хүний эрх, эрх чөлөөг хэрхэн зөрчигдөж, ялгаварлан гадуурхагдаж байгаа зарим асуудлыг илтгэлдээ багтаалаа. Мөн Монгол улс нь нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээ, конвенци, ялангуяа тус конвенцийн **Тавдугаар зүйлд** заасныг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх тодорхой, зохистой арга хэмжээг авч байгаагүй тул энэхүү илтгэлдээ тусгайлан анхаарч орууллаа.

1.1 Эмэгтэйчүүдийг ялгаварлах аливаа үйлдэл, үйл ажиллагаанаас татгалзах, төрийн байгууллага, алба энэхүү үүргийн дагуу ажиллахыг хангах талаар авсан арга хэмжээ (Конвенцийн 2)

Төрөөс эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, дорд үзэх хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх, эрх мэдлийн тэнцвэрт харилцааг бий болгох талаар дорвитой арга хэмжээ аваагүй. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа зан заншил, үйл ажиллагааг Төр таслан зогсоох, ялгаварлан гадуурхалтын суурь шалтгааныг арилгахын оронд харин ч өөрөө санаачилж, өөгшүүлэн дэвэргэсээр байна.

1.2 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг хориглосон хууль тогтоомж, түүний дагуу авсан арга хэмжээ (Конвенцийн 2,3-р зүйл)

Конвенцийн хэрэгжилтийг тайлагнах хугацаанд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиудыг баталсан, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн батлахаар УИХ дээр хэлэлцэж байгаа зэрэг ахиц дэвшил байгаа ч өмнө нь хэрэгжүүлж байсан бодлогын нааштай алхмуудаасаа ухарсан шийдвэрийг сүүлийн жилд Засгийн газар гаргаж байна.

1.2.1. Хүн амаа өсгөх пронаталист бодлого болон эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн хэрэгсэл мэт харж байгаа Засгийн газрын бодлого, түүний үр дагаврууд

Хүн амаа өсгөх зорилгоор төрөлтийг урамшуулж, бага хэмжээний бэлэн мөнгө тараах, хүүхэд асрах нь зөвхөн эмэгтэй хүний асуудал гэж үзэх хэвшмэл хандлагыг бэхжүүлсэн бодлогоос шалтгаалан төрөлт дагасан нийгмийн үйлчилгээний дэд бүтэц (төрөх газрууд, ясли, цэцэрлэг) орхигдсон. Ингэснээр эмэгтэйчүүдийн нуруун дээр хөлсгүй хөдөлмөрийн ачаалал бууж ирсэн. Төрийн энэ бодлогоос шалтгаалан эмэгтэйчүүд албан/хөлстэй хөдөлмөрийн зах зээл дээр нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас шалтгаалсан ялгаварлан гадуурхалтад өртөж, хүүхдээ өсгөх болон орлого хөдөлмөр эрхэлж, олох боломжийг хослуулах, өмчлөх, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломж нь хязгаарлагдаж, улам эмзэг, эрсдэлт байдалд орж байна.

Дүгнэлт

- Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, дорд үзэх явдал улс төр, эдийн засаг, гэр бүл, нийгмийн хүрээнд даяарчлалын сөрөг нөлөөнөөс цөөн хүн амтай улс орноо хамгаалж, соёлоо хэвээр хадгалж үлдэх болон хэт үндсэрхэг үзлийн нөлөөгөөр улам ихэсч байна.
- Энэ сөрөг соёл, уламжлал, зан заншлыг арилгах үүрэгтэй төр үүний суурь шалтгааныг арилгах талаар системтэй, шат дараалсан цогц арга хэмжээ авахын оронд бодлого, хуулиар улам бэхжүүлж, өмнөх жилүүдэд олсон ололт, амжилтаасаа үхарч байна.

Зөвлөмж

- Бүх шатны боловсролын байгууллага болон мэргэжилтэй боловсрон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулийн хөтөлбөрт хүний эрх, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалын талаарх агуулга оруулах;
- Хүн амын бодлогыг боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанарыг, нэмэгдүүлэх, гэр бүлд тулгарч байгаа хүүхэд өсгөх, сургах зардлыг бууруулах, хүүхдээ өсгөх, хөдөлмөр эрхлэх боломжийг уялдуулах зэрэг олон асуудлыг хамруулан цогцоор авч үзэх;
- Төрөх газруудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд, эх барих, хүүхэд, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ясли, цэцэрлэг, өдөр өнжүүлэх бүлэг байгуулж, нэр төрлийг нь олшруулах зэргээр сургуулийн өмнөх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Хүүхдээ асрах чөлөөг эцэг, эх ээлжлэн эдлэхийг дэмжих, энэ нь тэдний хөлстэй хөдөлмөр эрхлэлтэнд саад болохооргүй байхуйц уян хатан ажлын цаг, ээлтэй орчинг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэх;
- Жирэмсэн, амаржсан эхчүүд болон хүүхэд асрах чөлөө авсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг/эхэд сарын дундаж цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмж өгөх, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлөхөд чиглэсэн эрхзүйн орчин бүрдүүлэх;
- Эхнэр, нөхрийн гэрлэснээс хойш гэр ахуйн ажил ба өрхийн аж ахуй эрхэлсэн, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настныг асарсан зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээхэд болон өрхийн эдийн засагт оруулсан хувь хэмээн тооцох эрхзүйн орчинг бүрдүүлэх;
- Эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өмчлөх эрхийг баталгаажуулах, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх замаар тэдний эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх бодлогыг эмэгтэйчүүдийн амьдралын бүхий л хүрээнд цогцоор авч үзэж тодорхойлох
- Бүх шатны томилогдох албан тушаалд суудлын квотыг хэрэгжүүлэхээр хуульчилсан Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх;

ИЛТГЭЛИЙН АГУУЛГА

УДИРТГАЛ ХЭСЭГ

I ХЭСЭГ

Эмэгтэйчүүдийг ялгаварлах аливаа үйлдэл, үйл ажиллагаанаас татгалзах, төрийн байгууллага, алба энэхүү үүргийн дагуу ажиллахыг хангах талаар авсан арга хэмжээ (Конвенцийн 2 d)

1.1 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг хориглосон хууль тогтоомж, түүний дагуу авсан арга хэмжээ (Конвенцийн 2,3-р зүйл)

1.2 . Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүргийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд хийгдсэн үйл ажиллагаа (Конвенцийн 5-р зүйл)

II ХЭСЭГ

1.1 . Улс төр, нийгмийн амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцох боломжийг хангасан байдал (Конвенцийн 7,8-р зүйл)

III ХЭСЭГ

1.1 Боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 10-р зүйл)

1.2 Хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 11-р зүйл)

IV ХЭСЭГ

1.1 Гэрлэлт, гэр бүлийн харилцаа дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 16-р зүйл)

ХАВСРАЛТУУД

УДИРТГАЛ ХЭСЭГ

Монгол улсын талаарх ерөнхий танилцуулга

Монгол Улс нь Төв Азид оршдог. Хойд талаараа ОХУ, бусад талаараа БНХАУ-тай хиллэдэг. Хүн амын 95 хувь нь монгол, 4.9 хувь нь казак, 0.1 хувь нь бусад үндэстэнээс бүрдсэн. Хүн амын 99 хувь нь бичиг үсэг тайлагдсан.

Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш хүн амын хөдөөгөөс хот руу шилжих хөдөлгөөн ихэсч, одоо хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдрах болсон бөгөөд хотын хүн амын 65 хувь нь зөвхөн нийслэл Улаанбаатарт суурьшсан байна.¹

Монгол улсын хүн ам 2015 оны 1 сард 3 саяд хүрсэн. 2014 оны эцэст 2,995,949 байсан нийт хүн амын 51,46 хувь нь эмэгтэйчүүд байна.

Ажиллах хүчний судалгааны 2015 оны 1 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд ажиллах хүч буюу 15, түүнээс дээш насны эдийн засгийн идэвхтэй хүн ам 1205.5 мянга байгаагийн 632.1 мянга буюу 52.4 хувь нь эрэгтэй, 573.4 мянга буюу 47.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн ажиллах хүчний оролцооны түвшин улсын дунджаар 61.5%, Эрэгтэй 68.6%, Эмэгтэй 55.3% байна.

Эдийн засгийн идэвхгүй хүн ам улсын хэмжээнд нийтдээ 753.4 мянга байгаагаас 289.3 мянган эрэгтэй, 464.1 мянга буюу 61.6 хувь нь эмэгтэйчүүд байна². 2015 оны 1 дүгээр улиралд улсын хэмжээнд ажилгүй иргэд 88.6 мянга байгаагийн 53.6 мянга буюу 60.5 хувь нь эрэгтэйчүүд, 35.0 мянга буюу 39.5 хувь нь эмэгтэйчүүд байна.

2013 оны байдлаар өрх толгойлсон хүн ам нийтдээ 107.187 байгаагаас эмэгтэйчүүд – 81.741, эрэгтэй – 25.446 байна. Үүнээс 18 нас хүртлэх олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд 39.904 байна.

1 Монгол улсын төрөөс хүн амын талаар баримтлах цогц бодлогын төслөөс (УИХ-д өргөн баригдсан төсөл)

2 УСХ, 2015 оны 1 дүгээр улирлын тоон мэдээ.

Монгол Улс нь “эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно” хэмээн Үндсэн хуульдаа тунхагласан парламентын засаглалтай Бүгд Найрамдах Улс.

Монгол улс нь нүүдлийн соёл, ёс заншилтэй орон бөгөөд “**Монголын соёл** гэдэг бол байгалийн эрс тэс үүр амьсгалд нүүдэллэн оршиж амьдарсаар ирсэн нүүдэлчдийн соёлын өв уламжлал болон түүнд суурилагдсан суурин соёл иргэншлийн хэв маяг гэж ерөнхийд нь тодорхойлж болох юм” хэмээн Нэвтэрхий тольд дурджээ.³

Монгол улс нь 1990 оноос социалист тогтолцооноос татгалзаж, ардчилсан тогтолцоонд шилжиж, зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэх болсноос хойш 25 жил өнгөрч байна.

Монгол улсын төр нь үндэсний тусгаар тогтнол, эдийн засгийн хөгжлийг хангах нэрийдлээр, эмэгтэйчүүдийг хүн амаа бодлогын хэрэгсэл, үндэсний эрх ашигт үйлчлэх объект болгож харж, тэдний бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг зөрчиж байна. Төрийн энэ өрөөсгөл бодлого нь охид, эмэгтэйчүүдийн үнэлэмж, байр суурь, нөхөн үржихүйн үүрэг хариуцлага, хөдөлмөрийн хуваарилалттай холбоотой нийгэмд тогтсон хэвшмэл сөрөг хандлагыг улам бэхжүүлэх эрсдлийг авчирч байна.

I ХЭСЭГ

1.1. Эмэгтэйчүүдийг ялгаварлах аливаа үйлдэл, үйл ажиллагаанаас татгалзах, төрийн байгууллага, алба энэхүү үүргийн дагуу ажиллахыг хангах талаар авсан арга хэмжээ (Конвенцийн 2)

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 239 тоот “Монгол төрийн галыг бадраах тухай” зарлиг гарсан. Энэ зарлигийн дагуу тус оны 12 сарын 29-нд Төрийн ордны ёслол хүндэтгэлийн өргөөнд “Төрийн тулганы гал бадраах ёслол” зохион байгуулсан. Энэ ёслолдоо Засгийн газрын нөөц сангаас 360 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан ба Улсын Их Хурал, МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газраас зөвхөн эрчүүдийг онцлон урьж оролцуулсан. Харин төрийн болон хэвлэл мэдээллийн байгууллагаас нэг ч эмэгтэйг урьж оролцуулаагүй. УИХ-ын эмэгтэй гишүүдийг ч уриагүй.

Иймээс “төр, түүний тодорхой албан тушаалтан (УИХ-ын гишүүн) нийт иргэдийн татварын хөрөнгөөр үйл ажиллагаа зохион байгуулахдаа иргэдийг хүйс, шашин шүтлэгээр нь ялгаварлан гадуурхсан байна” гэж үзэж, иргэн Ж.Занаа Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасан. Үндсэн хуулийн цэц 2012 оны 3 сарын 05-ны өдөр “Төрийн тулганы гал бадраахдаа гэрийн суурь, тулганы галд эмэгтэй хүн гардаггүй уулын шорооны дээжийг залсан байх учир Үндсэн хууль зөрчөөгүй, монгол ардын уламжлалыг баримталсан байна” гэсэн үндэслэлээр маргаан үүсгэхээс татгалзах тухай 24 тоот тогтоол гаргасан.

2004 онд МУ-ын Ерөнхийлөгчөөс төрийн тахилгатай уул, овоог тахиx зарлиг гарснаас хойш төсвийн хөрөнгө үүнд зарцуулагдах болсон. Үүгээр ч зогсохгүй төдийгүй тухайн орон нутгийн албан тушаалтан, зарим иргэдийн зүгээс төрийн тахилгатай болсон уул, овоонд эмэгтэй хүн гаргахыг хориглох явдал нэмэгдсээр байна.

Дээрх жишээ нь эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа зан заншил, үйлдэл, үйл ажиллагааг Төр таслан зогсоох, ялгаварлан гадуурхалтын суурь шалтгааныг арилгахын оронд харин ч өөрөө санаачилж, өөгшүүлэн дэвэргэж байгааг харуулна.

³ https://mn.wikipedia.org/wiki/Монголын_соёл

1.2 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг хориглосон хууль тогтоомж, түүний дагуу авсан арга хэмжээ (Конвенцийн 2,3-р зүйл)

1992 онд батлагдсан Үндсэн хуульд “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүн тэгш эрхтэй”, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” (14.2), “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ, Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, (11), “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” (14.1) гэж тус тус заасан. Мөн “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай” (2011), Гэр бүлийн тухай (1999), Хөдөлмөрийн тухай (1999), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (2004), Хүн худалдаалахтай тэмцэх тухай (2012) зэрэг хуулиудад эрэгтэй, эмэгтэйчүүд хүний эрхээ тэгш, баталгаатай эдлэхийг заасан.

Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлд хүний “эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан.

Монгол улсын хууль, бодлого зэрэг эрхзүйн баримт бичгүүдэд эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг шууд байдлаар дорд үзэж, ялгаварлан гадуурхсан заалт байхгүй, бодит тэгш эрхийг ханган баталгаажуулах тогтолцоо, механизм сул, хангалтгүй хэвээр, төрийн зүгээс санхүүгийн дэмжлэг хангалтгүй, төрийн байгууллагууд боловсон хүчнээ системтэй, тогтмол бэлтгэх зэрэг зохистой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхгүй байгаагаас эмэгтэйчүүд Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажсан эрхээ бодитой эдэлж чадахгүй байна. Үүнээс шалтгаалан эмэгтэйчүүд улс төр, нийгэм, гэр бүлийн амьдралд эрэгтэйчүүдийн нэгэн адил тэгш эрхтэй оролцох боломж хумигдаж, төр, зах зээл, олон нийт, гэр бүлийн хүрээнд шууд ба шууд бус ялгаварлан гадуурхалт, бүх төрлийн хүчирхийлэл, дарамтанд өртсөөр байна.

Конвенцийн хэрэгжилтийг тайлагнах хугацаанд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиудыг тус тус баталсан, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг шинэчлэн батлахаар УИХ дээр хэлэлцэж байгаа зэрэг ахиц дэвшил гарч байгаа хэдий ч өмнө нь хэрэгжүүлж байсан бодлого, үйл ажиллагааны нааштай алхмуудаасаа ухарсан арга хэмжээнүүдийг сүүлийн жилүүдэд төрийн эрх барьж байгаа Засгийн газрууд авч байна. Тухайлбал:

- а) Хэдийгээр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд УИХ-аас, тус хуулийг хэрэгжүүлэх стратегийг 2014 онд Засгийн газраас тус тус баталсан ч уг хуулийг хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзэл хангалтгүй байна. 2014 оны 11 сард шинээр бүрдсэн Засгийн газар нь эдийн засаг хямарсан, хэмнэлтийн горимд шилжих болсон, чиг үүргийн давхардлыг арилгаж байгаа гэсэн шалтгаанаар салбар дундын зохицуулалтыг гүйцэтгэж байсан Жендэрийн үндэсний хорооны дэргэдэх бие даасан Ажлын албыг татан буулгаж, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны харъяанд шилжүүлсэн. Нэг яамны харъяанд энэ чиг үүрэг шилжсэнээр салбар хоорондын зохицуулалт болон gender mainstreaming хийх боломжийг байхгүй болгоод 8 сар болж байна. ТББ-үүд Ерөнхий сайдад хандан шаардах бичиг илгээсэн ч ямар ч хариу аваагүй. Ерөнхий сайд Жендэрийн үндэсний хороог тэргүүлдэг хэвээр учраас салбар хоорондын зохицуулалтыг хийх боломж нь хэвээр гэж Засгийн газар тайлбарлаж байгаа ч 2015 он гарсаар Жендэрийн үндэсний хороо нэг ч удаа хуралдаагүй.
- б) 2013 оны 7 сард УИХ-аас Гэрч, хохирогчийг хамгаалах хууль болон Тахарын албаны тухай хуулиудыг тус тус баталж, Тахарын албыг байгуулсан. Гэвч мөн л дээрхтэй ижил шалтгаанаар тус албыг татан буулгах оролдлого явагдаж байна. Шинээр байгуулагдсан Засгийн газар яам, агентлагуудаас 464 орон тоо цомхотгож, 13 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргах тооцоо хийж, “Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол гаргасан. 2014 оны 12 сарын 05-нд МУ-ын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг байгуулагдаад жил

гаруйн хугацаа өнгөрч байсан Тахарын албыг татан буулгах тогтоолыг УИХ-ын дарга З.Энхболдод өргөн барьсан. Зарим УИХ-ын гишүүдийн эсэргүүцсэнээр дахин судалж үзэхээр хойшлогдсон ч Хуульзүйн яамнаас УИХ-д өргөн баригдсан Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдэд тус албыг татан буулгах саналыг оруулаад байна. Тахарын алба байгуулагдсан цагаас эхлэн гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийлэл, хүн худалдаалах хэргийн хохирогчдыг хамгаалах ажлыг шуурхай, үр дүнтэй хийж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудтай нягт уялдаатай хамтран ажиллаж эхэлсэн. 200 гаруй ТББ-үүд нэгдэн 2015 оны 5 сарын 12-нд хэвлэлийн бага хурал хийж, МУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын даргад хандан шаардлага хүргүүлсэн ч хариу аваагүй байна.

Конвенцийн Хорооноос өгсөн Зөвлөмжийн 23-т “Конвенцийн үзэл санаанд үндэслэсэн хүний эрхийн болон жендерийн талаарх боловсрол олгох сургалтыг сургуулийн боловсролын хөтөлбөрт тусгах болон Конвенцийн 5-р зүйлд заасны дагуу эмэгтэй хүний үүрэг хэмээн тогтсон заншлыг өөрчлөхөд чиглэсэн сурталчилгаа явуулахыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд уриалахыг Гишүүн оронд зөвлөж байна” гэж заасан. Гэтэл энэхүү Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг Монголын Үндэсний Олон нийтийн Телевизийн сэтгүүлчийн өөрийнх нь санаачлагаар сар бүр хийж байгаа “Эрхзүйн хөтөч” нэвтрүүлгийг эс тооцвол төрөөс түүштай, системтэй, дэс дараатайгаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ байхгүй байна.

Конвенцийн хэрэгжилтийн асуудлаарх 5, 6 болон 7 дугаар ээлжит илтгэлээс хойш өнөөдрийн хүртлэх хугацаанд үндэсний хууль, тогтоомж, зарлиг зэрэг эрхзүйн баримт бичгүүдэд хүний эрх, жендерийн тэгш эрхийн тулгуур зарчим, хандлагаар хийсэн үнэлгээ, дүгнэлтийг төр, засгаас авч хэрэгжүүлээгүй байна. Энэ талаар Үндэсний Статистикийн Хороо (ҮСХ)-ны 2012 оны тайлан мэдээнд “Мянганы хөгжлийн зорилтын шалгуур үзүүлэлтүүдээс i) Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцэд нийцэж буй талаарх шинжээчдийн үнэлгээ, ii) Баг, хорооны Засаг даргад нэр дэвшүүлэхэд оролцох иргэдийн ирцийн хувь, iii) Хот, суурингийн нийт хүн амд хаягийн бүртгэлгүй

оршин суугчдын эзлэх хувь гэсэн 3 үзүүлэлтийг тооцоогүй байна” хэмээн дүгнэсэн байна⁴.

1.3 Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүргийн талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд хийгдсэн үйл ажиллагаа (Конвенцийн 5-р зүйл)

Конвенцид “Аль нэг хүйсийг доорд, эсхүл дээрд үзэх, эсхүл эрэгтэй, эмэгтэйчүүдийн үүргийн талаархи хэвшсэн үзэлд тулгуурласан хохиролтой үйл ажиллагаа, заншил болон бусад бүх дадлыг устгах зорилгоор эрэгтэй, эмэгтэйчүүдийн зан төлөвийн нийгэм, соёлын хэв шинжийг өөрчлөх”⁵ хэмээн заасан.

Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчлэхээр⁶ Монгол улсын Үндсэн хуулинд заасан.

Хэдийгээр манай улсын хууль тогтоомжид эмэгтэй, эрэгтэй хүмүүс тэгш байх, үл ялгаварлагдах тухай заалтууд хангалттай бий ч бодит амьдрал дээр энэ нь хангалттай хэрэгжихгүй байна. Улс төр, эдийн засаг, нийгэм, гэр бүлийн амьдралд байгаа эцгийн эрхэт ёсны уламжлал, соёлд дулдуйдсан эмэгтэйчүүдийг дорд үздэг хандлага, үйл ажиллагаа, заншлыг арилгах асуудлыг Монголын төр тогтолцооных нь хүрээнд цогц байдлаар авч үзэж, эмэгтэйчүүд ялгаварлагдан гадуурхагдаж байгаа суурь шалтгааныг арилгах талаар дорвитой, зоримог өөрчлөлт хийгдсэнгүй. Харин ч өмнө хүрсэн ололт, амжилтаасаа ухрах, эмэгтэйчүүдийн өмнө шинэ шинэ ялгаварлал, саад, бэрхшээлийг авчрах бодлого, хөтөлбөр, арга хэмжээнүүдийг Засгийн газар хэрэгжүүлэх боллоо.

Хүн амаа өсгөх пронаталист бодлого болон эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн хэрэгсэл мэт харж байгаа Засгийн газрын бодлого, түүний үр дагаврууд

Монгол улсын төр нь үндэсний тусгаар тогтнол, эдийн засгийн хөгжлийг хангах нэрийдлээр, эмэгтэйчүүдийг хүн амаа бодлогын хэрэгсэл, үндэсний эрх ашигт үйлчлэх объект болгож харж, тэдний бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг зөрчиж байна. Хүн амын тоо нэмэгдэх нь эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжил, амьдралын чанарт автоматаар эерэг нөлөө үзүүлэх мэт, хүн амын тоонд зөвхөн төрөлт нөлөөлдөг мэт

4 http://www.1212.mn/contents/stats/contents_stat_fld_tree_html.jsp

5 ЭЯГБХУТК, 5 дугаар заалт (а)

6 Монгол улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

ойлгож, төрөлтийн түвшинг нэмэгдүүлэхэд чиглэсэн өрөөсгөл, олон эрсдэл дагуулсан бодлого баримталж байна. Төрийн энэ өрөөсгөл бодлого нь охид, эмэгтэйчүүдийн үнэлэмж, байр суурь, нөхөн үржихүйн үүрэг хариуцлага, хөдөлмөрийн хуваарилалттай холбоотой нийгэмд тогтсон хэвшмэл сөрөг хандлагыг улам бэхжүүлэх эрсдлийг авчирч байна.

Эмэгтэйчүүдийн хүний эрхийг хангах арга хэмжээг зөвхөн эхийн хамгааллын хүрээнд авч хэрэгжүүлж байгаагаас нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас шалтгаалсан ялгаварлал, гадуурхал ихэсч байна.

4 жил тутам болдог УИХ-ын сонгуульд улс төрийн намууд өрсөлдөхдөө санал авах зорилгоор хүн амаа өсгөх бодлогод анхаарахаа илэрхийлж, төрөлтийг урамшуулах зорилгоор гэр бүл, хүүхдэд мөнгө тараах амлалт өгсөөр ирлээ. Сонгуульд ялсан нам Засгийн газраа бүрдүүлэхдээ мөрийн хөтөлбөртөө энэ амлалт, бодлогоо тусгасаар ирлээ. Үүнийг дараах баримтаас харж болно:

“Төрөлтийн түвшин 2005 онд 17.4 болж, түүхэндээ хамгийн бага түвшиндээ очиж байсан бол 2013 оны байдлаар төрөлтийн түвшин 27.5 болж, 1990 оноос хойшхи хугацаанд хамгийн өндөр түвшиндээ хүрсэн нь Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зөв бодлого, арга хэмжээ төрөлтийг, цаашлаад хүн амын өсөлтийг дэмждэг болохыг харуулж байна. Хүн амд хамгийн их хувийн жин эзэлж буй насны бүлэг 0-4, 20-24, 25-29 насныхан ба нөхөн үржихүйн идэвхтэй нас (20-29)-ны эмэгтэйчүүдийн тоо хамгийн өндөр байгаа нь төрөлт ойрын жилүүдэд ердийнхөөс нэмэгдэх магадлалыг илтгэж байна. Иймд нөхөн үржихүйн насны хүмүүс олон байгаа энэ үед төрөлтийг дэмжих таатай нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай юм.”⁷

Төрийн энэ бодлогоос шалтгаалан эмэгтэйчүүд албан/хөлстэй хөдөлмөрийн зах зээл дээр нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаас шалтгаалсан ялгаварлан гадуурхалтад өртөж, хүүхдээ өсгөх болон орлого хөдөлмөр эрхэлж, олох боломжийг хослуулах, өмчлөх, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломж нь хязгаарлагдаж, улам эмзэг, эрсдэлт байдалд орж байна.

Хүн амаа өсгөх зорилгоор төрөлтийг урамшуулж, бага хэмжээний бэлэн мөнгө тараах бодлого нь эмэгтэйчүүдийг ядууралд улам өртөмтгий болох нөхцлийг бүрдүүлж байна. Энэ нь тэдний мэргэжил эзэмших, хөлстэй хөдөлмөр эрхлэх, орлого олох, өмчтэй болох, мэргэжил дээрээ өсөх, ажил, албан тушаал ахих зэрэг урт хугацааны хөрөнгө оруулалтыг хааж байна.

Хүүхэд асрах нь зөвхөн эмэгтэй хүний асуудал гэж үзэх хэвшмэл хандлагыг бэхжүүлсэн бодлого нь төрөлт дагасан нийгмийн үйлчилгээний дэд бүтцийг орхигдуулсан. Ингэснээр эмэгтэйчүүдийн нуруун дээр хөлсгүй хөдөлмөрийн ачаалал бүүж ирсэн.

Төрөх газруудын даац: Жилд дунджаар 70 мянга гаруй хүн амаржиж байна. Улсын хэмжээний нийт төрөлтийн 45.8% буюу 30 гаруй мянга нь нийслэл Улаанбаатарт байна. Төрөх эмнэлгүүдийн ачаалал сүүлийн 3 жилд 20 гаруй хувиар өссөн. Нийслэлийн хүн ам 1.2 саяас хол давсан хэрнээ тус бүр 45-50 ортой 3-хан амаржих газартай. 2013 онд 1-р амаржих газар 150 ортой өргөтгөл барьсан. Маш их ачаалалтай, жирэмсний болон төрөхийн тусламж үйлчилгээний оочер дараалал урт байдаг. Эх баригч эмч нарын тоо хязгаарлагдмал, жирэмсэн эхчүүд эмнэлгийн үзлэгт хамрагдахын тулд үүрийн 5 цагаас оочер авах ёстой зэрэг асуудлаас шалтгаалан жирэмсний хяналтын тусламж үйлчилгээний чанар муу.⁸ Ор хүрэлцээгүйн улмаас ээжүүдийн заримыг коридортоо авахаас аргагүй болдог. Дөнгөж төрсөн нялх биетэй эхчүүдийг коридорт удаан хэвтүүлж болохгүй учраас нэг хонуулаад л гаргадаг.

3-р амаржих газар 105 ортой өргөтгөл барихаар төлөвлөгдсөн ч газар, төсвийн асуудал шийдэгдээгүйн улмаас өнөөг хүртэл бариагүй. 300 ортой 4-р амаржих газрыг барихаар 2010 онд шав тавьсан ч өнөөг хүртэл зураг, төслийг буруу хийсэн, төсвийн асуудал нь шийдэгдээгүйн улмаас ашиглалтанд ороогүй.

Сургуулийн өмнөх насны боловсролын байгууллагын хүртээмж: Хоёроос доош насны хүүхдийг асрах байгууллага огт байхгүй. Цэцэрлэгт хамрагдах ёстой хүүхдийн дөнгөж 40%-ийг л хамруулж байна. Өөрөөр хэлбэл 100 хүүхдээс 40-ийг нь авах ямар ч бололцоо байхгүй.

⁷ Монгол улсын төрөөс хүн амын талаар баримтлах цогц бодлогын төсөл (Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамнаас УИХ-д өргөн мэдүүлсэн)

⁸ Нөхцөл байдлын үнэлгээ, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх түгээмэл эрхийн хэрэгжилт, Монгол улс 2015, хуудас 11

Улсын хэмжээнд 2013 оны байдлаар 2-5 насны 247104 хүүхэд байгаагаас 61585 мянган хүүхэд буюу 4 хүүхэд тутмын 1 нь, нийслэлд 74900 хүүхэд байгаагаас 21400 мянган хүүхэд буюу 3 хүүхэд тутмын 1 нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна.⁹

Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаан дах ялгаварлан гадуурхалт:

Хүүхэд асрах үүрэг хариуцлагыг эцэг эх, тэгш хуваалцахыг дэмжсэн зохицуулалт байхгүй. Эмэгтэйчүүдийн хүний эрх, амьдралынх нь бүх хүрээг харгалзалгүй, зөвхөн “эх хүн” гэсэн нүдээр харсан өрөөсгөл бодлого хэрэгжүүлснээс ажил олгогчдын зүгээс залуу эмэгтэйчүүдийг ажилд авахаас төвөгшөөх хандлага гаргах зэргээр ялгаварлан гадуурхаж, эрхийг нь хязгаарлах явдал хөдөлмөрийн харилцаанд гарсаар байна.

Нөхөн үржихүйн үүрэг хариуцлагатай холбоотой дарамт, гэр орны ажлын ачаалал, цагийн хомсдол, хөдөлмөрийн ээлгүй орчин зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж, эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдаж байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх хүрээ тэлэхгүй, харин ч баталгаатай, нийгмийн даатгалд хамрагдсан, цалин хөлстэй ажлаас шахагдаж, албан бүс салбар, гэрийн хөдөлмөр лүү шилжиж байна. Үүнээс шалтгаалаад эмэгтэйчүүдийн боловсролдоо оруулсан хөрөнгө оруулалт үнэгүйдэж байна. 2000 онд 64.5 мянган эмэгтэй гэрийн ажилтай гэж бүртгэгдсэн бол 2010 онд 93.60 болжээ.¹⁰

Нөхцөл байдал ийм байхад төрийн зүгээс дүгнэлт хийж, засч залруулах арга хэмжээ авахын энэ бодлогоо улам бэхжүүлэхэд чиглэгдсэн “Монгол улсын төрөөс хүн ам, хөгжлийн талаар баримтлах цогц бодлого”-ын төслийг УИХ-д өргөн бариад байна. Мөн “Олуулаа” хуулийн төслийг боловсруулан, УИХ-д өргөн барихаар бэлтгэж байна.

“Монгол улсын төрөөс хүн ам, хөгжлийн талаар баримтлах цогц бодлого” нь 2025 он хүртэл хэрэгжихээр төсөлд тусгагдсан байна. Энэ бодлогын тэргүүлэх чиглэлийн нэгийг “Нөхөн үржихүйн насны хүн ам их байгааг түшиглэн эрүүл, чанартай төрөлтийг дэмжих таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалснаар хүн амын өсөлтийг тогтворжуулах” гэж тодорхойлжээ. Энэ чиглэлийн үр дүнгийн

шалгуур үзүүлэлтийг зөвхөн хүн амын жилийн дундаж өсөлт гэж авч үзсэн байх ба төрөлт дагасан нийгмийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх талаар огт тусгагдаагүй байна.

Мөн хөдөлмөрийн насны хүн амд хөдөлмөр эрхэлж, ажилтай орлоготой болох нөхцөлийг бүрдүүлэхийн тэргүүлэх чиглэлийнхээ нэг болгосон ба энэ хүрээнд дэвшүүлсэн зорилт, үр дүнгийн үзүүлэлтэд хүүхдээ өсгөхийг хөлстэй хөдөлмөр эрхлэхтэй хослуулах талаар огт дурдаагүй байна.

“Олуулаа” хуулийн төсөл нь хүний эрх, эмэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхэд суурилагүй; эмэгтэйчүүдийг нөхөн үржихүйн хэрэгсэл мэт харсан баримт бичиг болсон. Тухайлбал, тус хуулийн зорилт нь жирэмсэн болон 2 хүртэл насны хүүхдээ асарч байгаа, ихэр болон 3 ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлэн өсгөж байгаа эхэд тэтгэмж, хөнгөлөлт олгохтой харилцааг зохицуулахаар заажээ. Мөн 3 ба түүнээс дээш тооны хүүхэд төрүүлэн өсгөж байгаа эхэд сар бүр тэтгэмж олгохоос гадна 4 ба түүнээс дээш тооны хүүхэдтэй (2-18 хүртэлх насны) эх төлсөн хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөгдөхөөр онцгойлон тусгажээ. Энэ нь нөхөн үржихүйн үүрэг хариуцлагаасаа шалтгаалан залуу эмэгтэйчүүд ажлын байранд ялгаварлагдах, хөдөлмөрийн зах зээлээс шахагдах, нэг хүний цалин, орлогоор амьжиргаагаа залгуулахад хүргэх, хүүхэд асрах тэтгэмжээс өөр орлогогүй гэдгээр банкны шалгуурт унаж, орон сууцны зээл авч чадахгүй болох зэрэг эмзэг, эрсдэлт нөхцлүүдэд эмэгтэйчүүдийг төдийгүй залуу гэр бүлийг хүргэж байна.

9 УИХ-д өргөн баригдсан Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалаас

10 Үндэсний стандартчиллын хороо, хүн ам, орон сууцны улсын тооллогын үр дүн, 2010 он

II ХЭСЭГ

2.1. Улс төр, нийгмийн амьдралд эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцох боломжийг хангасан байдал (Конвенцийн 7, 8-р зүйл)

Монгол улсын Үндсэн хуульд Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцуудын тулгуур зарчмуудад нийцүүлэн “Хүн бүр улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй”, “Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ” хэмээн тэгш байх, ялгаварлан гадуурхахгүй байх, төр, засгийн үүрэг амлалтын зарчмуудад нийцүүлсэн заалтууд байдаг ч Жендэрийн эрх тэгш байдлыг тухай хуулийн Аравдугаар зүйлд “Төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд дараахь бодлого хэрэгжүүлнэ”, 10.1.1.томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл Засгийн газар, аймаг, нийслэлд 15 хувиас, дүүрэгт 20 хувиас, суманд 25 хувиас, хороонд 30 хувиас доошгүй байх; 10.1.2.төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх; 10.1.3.зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, авлигатай тэмцэх болон онцгой байдлын байгууллагаас бусад байгууллагын төрийн тусгай албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх” гэж эмэгтэйчүүдийн төлөөллийн доод хязгаарыг зааж оруулсан байдаг. Энэхүү заалтууд тэгш байдлын тэнцвэрийг хадгалах доод хязгаарыг зааж байгаа мэт харагдаж байгаа ч эцгийн эрхэт ёс, уламжлал, үйлдэл давамгайлсан манай улс төр, нийгмийн хүрээнд эмэгтэйчүүдийн төлөөллийн дээд хязгаар нь болж хэрэглэгдсээр олон жилийн нүүрийг үзэж байна. Дээрх хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээ авахгүй байна.

Улс төрийн намууд УИХ болон орон нутгийн сонгуулиар эмэгтэйчүүдийн сонгогдох бодит тэгш эрхийг баталгаажуулахад чиглэсэн түр, тусгай арга хэмжээг зохистой арга, хэлбэрээр, түүштай,

тогтвортой авч хэрэгжүүлэхгүй байна. Төр, засаг, олон нийт түр болон тусгай арга хэмжээний тухай эрх зүйн суурь ойлголт, утга учрыг мэддэггүй хэвээр байна. Тэд эмэгтэйчүүдийн хүч, мэдлэг, чадварыг эрэгтэйчүүдийн сонгуулийн кампанит үйл ажиллагаанд “туслан дэмжих” үүрэгтэйгээр ажиллуулдаг нь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог энэ хэмжээнд хязгаарлаж, “хууль болон бодлого боловсруулах ялангуяа дээд шатны байгууллагад эрэгтэйчүүд л ажиллах нь дээр” гэсэн үзэл, хандлагатай хэвээр байгааг харуулж байна.

Монгол улс эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй адил нөхцөлд олон улсын хэмжээнд өөрийн засгийн газрыг төлөөлөх, олон улсын байгууллагын үйл ажиллагаанд оролцуулж, нилээд хэдэн улс оронд элчин сайд болон бусад албан тушаалд томилж байгаа хэдий ч манай улстай улс төр, эдийн засаг болон нийгмийн бусад асуудлаар төдийлөн байнгын болон идэвхитэй харилцдаггүй улс оронд томилон явуулдаг байна.

III ХЭСЭГ

3.1. Боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 10-р зүйл)

Монгол улсад бүр шатны сургуульд 939.5 мянган хүүхэд, залуус суралцаж байгаа нь 2014-2015 оны хичээлийн жилийнхтэй харьцуулахад өмнөх оныхоос 2.8 хувиар өссөн ба дунджаар 60 гаруй хувь нь эмэгтэй суралцагчид байдаг. Энэ хичээлийн жилд их, дээд сургууль, коллеж нийт 101 сургууль байгаагийн 16 нь улсынх, 80 нь хувийн, 5 нь гадаадын сургуулиудын салбар байна.

Монгол улсад сургууль, боловсролын байгууллагад суралцаж байгаа суралцагчдын дийлэнх нь эмэгтэй суралцагчид байдгаас эмэгтэйчүүдийн боловсрох эрх чамлалтгүй хэрэгжиж байгаа мэт харагдавч эдгээр охид эмэгтэйчүүд дээд боловсролын диплом авсаны дараа ажлын байраар хангагдах баталгаагүй хэвээр байна. *Жишээнь, Ж. Гэдэг эмэгтэй Хуулийн Их сургууль болон Удирдлагын Академийг төгссөн хэдий ч ажлын байр байхгүй, ажилд орохоор олон газарт бүртгүүлсэн ч ямар ч үр дүн гараагүй бөгөөд одоо хувийн жижиг тэргээрээ таксины үйлчилгээ хийж амьдралаа залгуулж байгаа тухайгаа ярьж байна.*

Дээрх мэт олон мянган жишээгээр эмэгтэйчүүд бүрэн дунд, дээд боловсролтой болохын тулд өөрийн хирээс хэтэрсэн төлбөр төлж байгаа ч хувьдаа оруулсан тэр их хөрөнгө, мөнгөнийхээ үр дүн, үр шимийг тэр бүр эдэлж чадахгүй байна.

Түүнчлэн боловсролын олон шатны байгууллагуудад цөөнгүй тохиолдож байдаг сурах болон хөгжих эрхэд бүдүүлгээр халддаг ажлын байран дахь бэлгийн дарамтын асуудал анхаарал татахуйц хэмжээнд байна. Тэгсэн хэдий ч олон дунд болон дээд сургуулиадад суралцаж байгаа эмэгтэй оюутнуудын нэр хүндэд энэ асуудал муугаар нөлөөлдөг учраас сургуулийн орчинд болсон бэлгийн дарамтын асуудал дийлэнхдээ нуугдмал байдалтай хэвээр байна. Санаа зовоож байгаа өөр төрлийн асуудлууд бол амьдралын нөхцөл байдал, хэрэглээний үнэ цэнэтэй харьцуулахад хавьгүй өндөр байгаагаас их, дээд сургуулийн эмэгтэй оюутнууд бие үнэлэх тохиолдол багагүй газар авсан тухай аман мэдээллүүд ч байна. Мөн бүрэн бус дунд сургуулийн хичээлийн байранд бага ангийн охидыг хүчиндсэн үйлдэл одоогоос 3 жилийн өмнө гарч байсан. Энэ нь сургуулийн орчинд охид болон залуу эмэгтэйчүүд сурах, боловсрох эрх, эрх чөлөөгөө эдлэхэд чиглэсэн зохистой аюулгүй орчин, нөхцөлийг бүрдүүлж чадаагүй байгаатай холбоотой юм.

Дашрамд дурдахад Монгол улсад боловсролын чанар сул, цэцэрлэг, сургууль болон багшлах боловсон хүчний нэн их дутагдалтай, сургуулийн бүх шатны боловсролын сургалтын утга агуулгыг олон удаа өөрчилж суралцагсадыг “туршилтын түүлай” болгож байсан, , Кембрижийн сургалтын агуулга, системийг хэдхэн тооны сургуульд туршиж байгаа, нэг төрлийн шинжлэх ухаанаар өөр өөр сурах бичиг ашигладаг зэрэг олон шалтгаанаар боловсрол эзэмшээд төгсөж байгаа хүүхэд, залуучуудын мэдлэг, чадвар нь бодит амьдралын хэрэгцээ, шаардлагад тэр бүр нийцэхгүй байх нь олонтой байна.

2015 оны 2 сард батлагдсан Монгол хэлний тухай хуулийн 6.3-т “Төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг болон гадаад хэл заах тусгай зөвшөөрөл бүхий ерөнхий боловсролын сургуулиас бусад ерөнхий боловсролын сургуульд гадаад хэлийг тавдугаар ангиас эхлэн зааж болно” гэж заасан нь нэг талаас, нийтийн боловсролын стандартыг эвдэлж байгаа, нөгөө талаас элитист бодлогыг дэврээж байгаа, тэгш байдал, ялгаварлан гадуурхахгүй

байдлын эсрэг чиглэсэн хууль болсон гэж үзэхэд хүргэж байна.

Монгол улсад баян, ядуугийн ялгаа улам бүр ихсэж байгаагаас эмэгтэйчүүд, ялангуяа ерх толгойлсон эмэгтэйчүүд, эдийн засгийн идэвхитэй насны хүн амын бүлэгт багтаж байгаа хэдий ч эрхэлсэн ажилгүй, эсвэл цалин орлого багатай салбарт ажилладаг тул энэ элитист бодлогын золиос болж байна.

3.2. Хөдөлмөр эрхлэлтийн салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 11-р зүйл)

15-аас түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал. 2015 оны эхний 4 сарын байдлаар: ¹¹

Үзүүлэлт	2015 1/4		
	Нийт	Эрэгтэй	Эмэгтэй
15-аас түүнээс дээш насны хүн ам (мян. хүн)	1.958.899	921.376	1.037.507
Эдийн засгийн идэвхитэй хүн ам (мян.хүн)	1.205.496	632.064	573.432
Эдийн засгийн идэвхгүй хүн ам (мян.хүн)	753.387	289.312	464.075
Ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)	61.5	68.6	55.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин (хувь)	57	62.8	51.9
Ажилгүйдлийн түвшин (хувь)	7.4	8.5	6.1

Дээрхи хүснэгтээс харахад 15-аас дээш насны хүн амд ноогдох эмэгтэйчүүд нийтдээ 52.9 хувийг эзэлж байгаа ч эдийн засгийн идэвхитэй хүн амын ...хувь, эдийн засгийн идэвхигүй хүн амын ...хувь, ажиллах хүчний оролцооны 13.3 пунктээр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь 10.7 пунктээр, ажилгүйдлийн түвшин нь 2.4 пунктээр тус тус бага байгаа нь эмэгтэйчүүд хөдөлмөрлөх, цалин орлогоо нэмэгдүүлэх эрхээ эдлэх боломжоор хомс, тэднийг ажлын байраар хангах, эдийн засгийн чадавхиа нэмэгдүүлэхэд нь төр, засаг зохистой түвшинд анхаарахгүй

11 http://www.1212.mn/statHtml/print.do?orgId=976&tblId=DT_NSQ_0400_006V1

байгааг илтгэж байна. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2015 оны 4 дүгээр сарын эцэст 48.5 мянга байгаагаас 25.4 мянга нь эмэгтэйчүүд байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 17.9 мянга буюу 53.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 пунктээр өсчээ¹².

Дээрх статистик үзүүлэлт нь эмэгтэйчүүд эдийн засаг, нийгмийн болон улс төр, соёлын эрхээ хангалттай эдлэхэд сөргөөр нөлөөлөх эдийн засгийн хүчин зүйлс байсаар байгааг харуулж байгаа бөгөөд “ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлийн нийгэм байгуулж байгаа” нэрийдлээр эмэгтэйчүүд хөдөлмөрлөх эрхээ эдлэх орчин, нөхцөлийг хангасан бодлого, хууль, үйл ажиллагааг бодитой хэрэгжүүлэхийн оронд Конвенци болон Үндсэн хуульд заасан, баталгаатай эдлэх ёстой тэдний эрхийг зөрчиж, шууд ба шууд бусаар ялгаварлан гадуурхаж байгааг илтгэж байна.

IV ХЭСЭГ

4.1. Гэрлэлт, гэр бүлийн харилцаа дахь жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилт (Конвенцийн 16-р зүйл)

Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах цогц бодлогын шинэчлэн найруулж байгаа төслийн “Гэр бүл төвтэй хүний хөгжлийг хангах” гэсэн Зарчмын хэсэгт “Гэр бүл бол нийгмийн, хүн амын нөхөн үржихүйн үндсэн нэгж хэмээн хүлээн зөвшөөрөх”, гэр бүлийн хөгжлийг дэмжих замаар хүний хөгжлийг дэмжих, хүүхэд, залуучууд, настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэр бүлийн хүрээнд хөгжүүлэн хамгаална гэж заасан.

Гэр бүлийн тухай хуулийн Гуравдугаар зүйлд “гэр бүл” гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг” гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолтоос дүгнэхэд өрх толгойлсон, ганц бие эмэгтэйчүүд Хүн амын хөгжлийн цогц бодлогод хамаарахгүй шоовдорлогдсон бүлэгт орох магадлалтай байна.

Түүнээс гадна хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжихдээ “Нөхөн үржихүйн насны хүн ам их байгааг түшиглэн эрүүл, чанартай төрөлтийг дэмжих таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүн амын эрүүл мэндийг хамгаалснаар хүн амын өсөлтийг тогтворжуулах”, “Хүүхэд, залуучуудын боловсрол, соёлын хэрэгцээг ханган хөгжүүлснээр бүтээлч чадамжтай хүний нөөцийг тогтмол нэмэгдүүлэх”, “Хүн ам зүйн цонх үеийн хөдөлмөрийн насны хүн амын их нөөцийг үр дүнтэй ашиглах үүднээс хөдөлмөрийн насны хүн амд хөдөлмөр эрхэлж, ажилтай орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх”, “Улс оронд хурдацтай нүүрлэж буй насжилтын асуудлыг анхаарч, хүн амыг эрүүл насжилтад бэлтгэх, ирээдүйн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн үйлчилгээнд шаардлагатай хуримлалыг бий болгох”, “Хүн ам эрүүл аюулгүй амьдрах орчныг бүрдүүлж, амьдралын чанарыг сайжруулах” гэхчилэн тэргүүлэх чиглэлүүдээ заасан байна.

Гэсэн хэдий ч одоогийн төр, засгаас явуулж байгаа нийгэм, эдийн засгийн бодлого, ялангуяа эдийн засгийг сэргээх магадлал хамгийн их байгаа уул, уурхайг ашиглах гэрээнүүд нь дийлэнхдээ гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг үнэмлэхүй ихээр дэмжсэн, баялагын дахин хувиарлалтыг тэгш бус, шударга бус байхаар хийгдэж байгаа нь хүн ам, гэр бүлийн хөгжилд тус нэмэр муутай, нийгмийн ядуу, дунд давхаргад ямар ч ашиггүй байхаар харагдаж байна.

Монголын эдийн засгийн байдал эрх баригчдын ярьж байгаагаас хавьгүй дорд орсон байгаа нь эдийн засгийн идэвхитэй хүн амын дийлэнхийг эзэлж байгаа ч, ажил, хөдөлмөр эрхлээгүй хүн амын дийлэнхийг эзэлж байгаа эмэгтэйчүүдэд, ялангуяа өрх толгойлсон, олон хүүхэдтэй эмэгтэйчүүдийн амьдрал улам бүр доройтоход хүргэж байна.

Дүгнэлт

Монгол улс Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийн устгах тухай НҮБ-н конвенцид 1981 онд нэгдэж орсоноос хойш 34 жил өнгөрч байгаа хэдий ч энэхүү Конвенцийг эмэгтэйчүүдийн хүний эрхийг ханган баталгаажуулах тулгуур зарчимд үндэслэж хэрэгжүүлдэггүй, ээлжит тайлангуудыг нэр төдий бэлтгэдэг, Хорооноос өгсөн Зөвлөмжийг бодит байдалд хэрэгжүүлэх улс төрийн хүсэл эрмэлзлэл байдаггүй зэргээс үүдэн эмэгтэйчүүдийн улс төр, нийгэм, эдийн

¹² http://www.1212.mn/statHtml/print.do?orgId=976&tblId=DT_NSO_0400_006V1

засаг, соёлын эрхүүд бодитой хэрэгжихгүй байна.

Төр, засгаас Конвенцийн Нэгдүгээр хэсэгт заасан үүрэг, хариуцлагаа маш хангалтгүй анхаарч, бодитой хэрэгжүүлэх тогтолцооны болон зохион байгуулалтын арга хэмжээг зохистой хэлбэрээр, түүштай хэрэгжүүлж байсангүй.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, дорд үзэх явдал улс төр, эдийн засаг, гэр бүл, нийгмийн хүрээнд даяарчлалын сөрөг нөлөөнөөс цөөн хүн амтай улс орноо хамгаалж, соёлоо хэвээр хадгалж үлдэх болон хэт үндсэрхэг үзлийн нөлөөгөөр улам ихэсч байна. Энэ сөрөг соёл, уламжлал, зан заншлыг арилгах үүрэгтэй төр үүний суурь шалтгааныг арилгах талаар системтэй, шат дараалсан цогц арга хэмжээг авахын оронд бодлого, хуулиар бэхжүүлэн, өмнөх жилүүдэд олсон ололт, амжилтаасаа ухарч байна.

1992 онд баталсан Ардчилсан Үндсэн хуульд “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүн тэгш эрхтэй”, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” (14.2), “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. (11), “Хүн бүр эрх зүйн этгээд байна”, “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” (14.1), Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ, Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” (70.1), “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” (10.3), “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” (10.3) хэмээн заасан боловч Үндсэн хуулийг нийгмийн бүх салбарт бодитой хэрэгжүүлэх хууль, бодлого, хөтөлбөрийг нарийвчлан боловсруулж, найдвартай тогтолцоо, механизмыг санхүүгийн боломж бололцоогоор хангаж ажиллуулах талаар маш хангалтгүй анхаарч байна.

Ардчилсан нийгэм, чөлөөт зах зээлийн нийгэмд ажиллаж, амьдарч байгаа монголын эмэгтэйчүүд баян, ядуу, хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн болон боловсролын ялгаа, мэрэгжлийн үр чадвар, нийгмийн байдал, хот, хөдөөгийн болон эрх мэдлийн ялгаа зэрэг олон ялгаанаас болж төрөл бүрийн ялгаварлан гадуурхалтанд байнга өртсөн хэвээр байна.

Тус Конвенцийн хэрэгжилтийг 1996 онд байгуулагдаж байсан Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах Конвенцийн хэрэгжилтийг хянах Үндэсний сүлжээнд нэгдсэн эмэгтэйчүүдийн ТББ-аас явуулж байсан удаа дараагийн төрөл бүрийн сургалт, семинар, 3 удаагийн судалгаа, Сүүдэр илтгэлүүдийг эс тооцвол төр, засгийн зүгээс энэхүү Конвенцийн талаарх төр, олон нийтийн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг сайжруулах талаар бодитой арга хэмжээ авч байгаагүй болно.

Түүнээс гадна НҮБ болон НҮБХХ газараас Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ-аас батлан гаргасан хүний эрх болон эмэгтэйчүүдийн эрхийн Конвенцуудын хэрэгжилтийн асуудлаар хяналт, мониторингийн ажиллагаа явуулах, Сүүдэр илтгэл бичих зэрэгт санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүй байна. Энэ байдал нь хүний эрх, эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн тэгш эрхийн бодит хэрэгжилтийг сайжруулахын төлөө үйгагүй, түүштай ажиллаж байгаа хувь хүн, ТББ байгууллага, бүлгүүдийн чин эрмэлзлэл, чадавхи, ардчилсан, хүмүүнлэг нийгмийг хөгжүүлэхэд иргэдийн утга учиртай оролцоог дэмжих НҮБ-ын зорилгод нийцэхгүй байна.

Тиймээс хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцуудын хэрэгжилтийн асуудлаар, ялангуяа эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай Конвенцийн хэрэгжилтийн асуудлаар ээлжит тайлан бэлтгэж байгаа улс орнуудын эмэгтэйчүүдийн ТББ-аас Сүүдэр илтгэл бичих, боловсруулах, орчуулах үйл ажиллагаанд санхүүгийн тодорхой зардал төлөвлөж байхыг Хороонд санал болгож байна.

ЗӨВЛӨМЖ

- Хүн амын бодлогыг боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж, чанарыг, нэмэгдүүлэх, гэр бүлд тулгарч байгаа хүүхэд өсгөх, сургах зардлыг бууруулах, хүүхдээ өсгөх, хөдөлмөр эрхлэх боломжийг уялдуулах зэрэг олон асуудлыг хамруулан цогцоор авч үзэх
- Төрөх газруудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүд, эх барих, хүүхэд, нярайн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, ясли, цэцэрлэг, өдөр өнжүүлэх бүлэг байгуулж, нэр төрлийг нь олшруулах зэргээр сургуулийн өмнөх боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Хүүхдээ асрах чөлөөг эцэг, эх ээлжлэн эдлэхийг дэмжих, энэ нь тэдний хөлстэй хөдөлмөр эрхлэлтэнд саад болохооргүй байхуйц уян хатан ажлын цаг, ээлтэй орчинг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлэх;
- Жирэмсэн, амаржсан эхчүүд болон хүүхэд асрах чөлөө авсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг/эхэд сарын дундаж цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмж өгөх, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлөхөд чиглэсэн эрхзүйн орчин бүрдүүлэх;
- Эхнэр, нөхрийн гэрлэснээс хойш гэр ахуйн ажил ба өрхийн аж ахуй эрхэлсэн, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настныг асарсан зэрэг гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлгээг нийгмийн баялаг бүтээхэд болон өрхийн эдийн засагт оруулсан хувь хэмээн тооцох эрхзүйн орчинг бүрдүүлэх; Эмэгтэйчүүдийн хөлстэй хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өмчлөх эрхийг баталгаажуулах, нийгмийн баялгаас тэгш хүртэх боломжийг нэмэгдүүлэх замаар тэдний эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх бодлогыг эмэгтэйчүүдийн амьдралын бүхий л хүрээнд цогцоор авч үзэж тодорхойлох
- Бүх шатны томилогдох албан тушаалд суудлын квотыг хэрэгжүүлэхээр хуульчилсан Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийг хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх;

ХАВСРАЛТУУД

1. Нөхцөл байдлын үнэлгээ : Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх түгээмэл эрхийн хэрэгжилт, Монгол улс 2015
2. Нөхцөл байдлын үнэлгээ: Бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийн хэрэгжилт, Монгол улс 2015